

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАР

АУДИТЫН КОД: ТӨА-2024/11/-НА-СТА-ОНА

ЗААМАРЫН ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал.....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.5.1 Завсрын аудитын талаар.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Төлбөрийн акт	13
5.2 Албан шаардлага.....	14
5.3 Зөвлөмж.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	15
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	15
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	15
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХК	Төрийн өмчит Хувьцаат компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 01/2024
танай _____-ны № _____-т

Г.ЗААМАРЫН ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ТУНГАЛАГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт өглөг, авлагын тооцооны данстай холбоотой санхүүгийн тогтвортой байдалд бэрхшээл учирч болзошгүй 117,816.5 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг", "ангилал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь сумын Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулан Уртын жалгын засварын ажил, Өл халзангийн давааны зам засварын ажил, ногоон тэжээл тариалах, хадлан тэжээл бэлтгэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Заамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 08 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн хөрөнгө болон нийгмийн хариуцлагын хүрээнд бий болсон 386,812.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Заамарын хөгжил ОНӨААТҮГ-т эзэмшүүлсэн шийдвэр гарсан байна.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулах 26,974.9 мянган төгрөгийн түүхий эд бараа материалын эргэлтийн хөрөнгөтэй болсон байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулах замаар сумын дэд бүтэц, хог хаягдал, гадна талбайн цэвэрлэгээг хариуцан олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг эрхэлж, тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгыг 48.1 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөл 3 удаа хуралдаж байгууллагын 2023 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, хөдөлмөрийн дотоод журмыг баталж, гүйцэтгэх захиралтай тусгай нөхцөлт хөдөлмөрийн гэрээг байгуулан ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	22,816,078.24	34,344,957.48
1.1.2	Дансны авлага	1,461,509.00	7,300,000.00
1.1.6	Бараа материал	-	26,974,900.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	24,277,587.24	68,619,857.48
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	383,105,058.00	352,197,881.40
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	383,105,058.00	352,197,881.40
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	407,382,645.24	420,817,738.88
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	10,262,019.00	28,194,244.00
2.1.1.2	Цалингийн өглөг	-	23,851,780.55
2.1.1.3	Татварын өр	2,287,305.05	11,063,699.80
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	19,303,063.72
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	28,103,711.86
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,549,324.05	110,516,499.93
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	12,549,324.05	110,516,499.93
2.3.2	Хувийн өмч	387,441,766.00	387,441,766.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	7,391,555.19	(77,140,527.05)
2.3.20	Эздийн өмчийн дүн	394,833,321.19	310,301,238.95
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	407,382,645.24	420,817,738.88

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	82,102,314.44	88,238,175.45
2	Борлуулалтын өртөг	35,602,288.00	111,419,468.95
3	Нийт ашиг (алдагдал)	46,500,026.44	(23,181,293.50)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	38,478,107.75	61,749,171.19
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	8,021,918.69	(84,930,464.69)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	7,391,555.19	(84,930,464.69)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	7,391,555.19	(84,930,464.69)
24	Орлогын нийт дүн	7,391,555.19	(84,930,464.69)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	82,937,705.35	125,165,704.76
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	82,937,705.35	125,165,704.76
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	41,677,715.74	106,675,825.52
	Ажиллагчдад төлсөн	11,850,022.69	39,665,987.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,341,992.42	-
	Бараа материал худалдан авахад төлсөн	9,291,038.63	44,650,714.88
	Ашиглалтын зардалд төлсөн	17,699.00	269,633.00
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	21,123,026.00
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	1,089,563.00	760,264.64
	Бусад мөнгөн зарлага	16,087,400.00	206,200.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	41,259,989.61	18,489,879.24
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	6,961,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	6,961,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(6,961,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,452,440.00	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,452,440.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	28,916,351.37	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	28,916,351.37	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(18,463,911.37)	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	22,796,078.24	11,528,879.24
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,000.00	22,816,078.24
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,816,078.24	34,344,957.48

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	20,000.00	0	0	20,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,000.00	0	0	20,000.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	394,813,321.19	394,813,321.19
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,000.00	0	394,813,321.19	394,833,321.19
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	20,000.00	0	394,813,321.19	394,833,321.19
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-387,023,383.55	-387,023,383.55
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,000.00	0	7,789,937.64	7,809,937.64
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	387,421,766.00	0	-84,930,464.69	302,491,301.31
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	387,441,766.00	0	-77,140,527.05	310,301,238.95

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	310,000,000.00	113,636,825.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	260,000,000.00	113,636,825.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	260,000,000.00	113,636,825.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,000,000.00	39,665,987.00
210101	Үндсэн цалин	56,000,000.00	39,665,987.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,000,000.00	0
210201	Тэтгэврийн даатгал	90,000,000.00	0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,000,000.00	269,633.00
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	269,633.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,000,000.00	21,123,026.00
210402	Тээвэр, шатахуун	50,000,000.00	21,123,026.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	2,000,000.00	966,464.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	2,000,000.00	966,464.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,000,000.00	51,611,714.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,000,000.00	51,611,714.88
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,000,000.00	0
220001	Барилга байгууламж	10,000,000.00	0
221001	Их засвар	10,000,000.00	0
222001	Тоног төхөөрөмж	10,000,000.00	0
223001	Бусад хөрөнгө	10,000,000.00	0
224001	Стратегийн нөөц хөрөнгө	10,000,000.00	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	310,000,000.00	125,165,704.76
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	310,000,000.00	125,165,704.76
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	260,000,000.00	125,165,704.76
350002	Түслэх үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000,000.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	22,816,078.24
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,816,078.24	34,344,957.48

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ОНӨААТҮГ/, түүний үйл ажиллагаа

Заамар сумын ИТХ-ын 2021 оны 27 дугаар тогтоолоор Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын дүрмээ батлуулсан бөгөөд энэхүү дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “ Газар нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр сумын хэмжээнд явуулна. Үүнд:

- Хог хаягдлыг ангилан ялгах, зориулалтын дагуу булах, булшлах
- Цэвэр бохир усны шугам сүлжээний завсар, хамгаалалт
- Дулаан хангамж
- Малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх
- Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх
- Гэрэлтүүлэг
- Суурьшлын орчны нөхөн сэргээлт
- Байгаль орчны нөхөн сэргээлт
- Бусад

гэж тодорхойлсон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 2023 оны зорилтын түвшинг 4 чиглэлийн хүрээнд тодорхойлж, баталсан байна.

Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь 2023 онд 9 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ыг Заамар сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 16 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4-д “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэж сумын ИТХ-ын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэсэн байна.

Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь дүрмийнхээ 1.2-д дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулахаар заасан байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, “Аймгийн өмчийн харилцааг зохицуулах журам”, сумын Засаг даргын захирамж, Үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн жилийн төлөвлөгөө болно.

Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын ТУЗ-өөс хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэж, 2024 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 1/29 тоотой Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 420,817.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,435.1 мянган төгрөгөөр буюу 3,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22,816.1	34,345.0	11,528.9
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	1,461.5	7,300.0	5,838.5
Бараа материал	0.0	26,974.9	26,974.9
Үндсэн хөрөнгө	383,105.1	352,197.9	-30,907.2
Нийт хөрөнгө	407,382.7	420,817.8	13,435.1
Өр төлбөр	12,549.3	110,516.5	97,967.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	394,833.4	310,301.3	-84,532.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	407,382.7	420,817.8	13,435.1

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 11,528.9 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст Үйлсийн зам ХХК-аас 28,103.7 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого дансанд орж, зарцуулалт хийгээгүйтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 5,838.5 мянган төгрөгөөр өссөн нь Заамар сумын ЗДТГ-т нийлүүлсэн 7,300.0 мянган төгрөгийн өвс, ногоон тэжээлийн тооцоололд тодорхойгүй байдал үүссэнтэй холбоотой байна.

Бараа материал данс оны эхэнд үлдэгдэлгүй байсан, эцсийн үлдэгдэл 26,974.9 мянган төгрөг болж өссөн нь үйл ажиллагаа явуулах 6,533.0 мянган төгрөгийн хангамжийн материал, 20,441.9 мянган төгрөгийн түүхий эд бараа материалын эргэлтийн хөрөнгө бэлтгэсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 383,105.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 352,197.9 мянган төгрөг болж, 30,907.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд 4,510.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмжид сайжруулалт хийж, 3,500.0 мянган төгрөгөөр гэр худалдан авч, нийт 8,010.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн бөгөөд тайлант онд 38,917.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой байна.

Тайлант оны өглөгийн эхний үлдэгдэл 12,549.3 мянган төгрөг байсан, шинээр 162,440.3 мянган төгрөгийн өглөг үүсэж, 62,613.2 мянган төгрөгийн тооцоог төлж, эцсийн үлдэгдэл 110,516.5 мянган төгрөг болж, өмнөх оны өглөгөөс 97,967.2 мянган төгрөгөөр өсөж нийт өмчийн 26,3 хувийг эзэлж байна.

Энэ нь үйл ажиллагаа, эргэлтийн хөрөнгө бэлтгэхтэй холбоотойгоор үүссэн байгууллага, иргэнд төлөх дансны өглөг 28,194.2 мянган төгрөг, цалингийн өглөг 23,851.8 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын өглөг 5,748.0 мянган төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг 5,315.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 19,303.0 мянган төгрөг, урьдчилж орсон орлого 28,103.7 мянган төгрөгөөс бүрдэж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 310,301.3 мянган төгрөг болж 84,532.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-д “ төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох”, 20 дугаар зүйлийн 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;” гэж заасны дагуу Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн

төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангуулах үүрэгтэй.

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын ТУЗ-ын 2023 оны 5 дугаар сарын 04-ний хурлын тогтоолоор 2023 онд 4 төрлийн ажлыг гүйцэтгэж 260,000.0 мянган төгрөгийн орлого, 140,000.0 мянган төгрөгийн зардал, 120,000.0 мянган төгрөгийн ашигтай ажиллах зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан, хөрөнгө оруулалтыг 50,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 125,165.7 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд урьдчилж орсон орлогоор Үйлсийн зам ХХК-аас орсон 28,103.7 мянган төгрөг, НӨАТ 8,823.8 мянган төгрөг, борлуулалтын орлого 88,238.2 мянган төгрөг байна.

Борлуулалтын өртөг 111,419.5 мянган төгрөг, ерөнхий ба удирдлагын зардал 61,749.2 мянган төгрөг, нийт зардал 173,168.7 мянган төгрөг зарцуулж, 84,930.5 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж зорилтот түвшинг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Зорилтот түвшний орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хийгдэх ажлууд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Сум орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлууд	60,000.0	70,783.3	10,783.3	118%
2	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх	50,000.0	0.0	(50,000.0)	0
3	Техникийн түрээсийн үйл ажиллагаа	100,000.0	46,128.8	(53,871.2)	46.1%
4	Өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд	50,000.0	8,253.6	(41,746.4)	16.5%
	Дүн	260,000.0	125,165.7	(143,087.9)	48.1%

Заамар сумын 100 жилийн ойн хүрээний ажилд дайчлагдаж ажилласнаас техникийн түрээсийн гэрээ цуцлагдаж, төлөвлөсөн хэмжээнд олох орлого 46.1 хувьтай хэрэгжсэн байна.

Өөрийн эзэмшлийн газаргүйгээс үржил шим муутай талбайд тариалалт хийсэн, эргэлтийн хөрөнгөгүйгээс ургамлын болц хугацаа алдсан зэргээс шалтгаалан алдагдал үүссэн байна.

Батлагдсан зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь ТУЗ-ын тогтоолоор 2023 онд 5 төрлийн хөрөнгө худалдан авахаар хөрөнгө оруулалтыг 50,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж батлуулсан байна.

Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийгдээгүй байна. Үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгцээтэй автогрейдэрт 4,510.0 мянган төгрөгийн сэлбэг авч, сайжруулалт хийсэн бөгөөд, ажилчид түр байрлах гэр 3,500.0 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Заамарын хөгжил ОНӨААТҮГ -ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 1/29 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн 2023 оны орлогын төлөвлөгөөний нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 2023 оны батлагдсан зорилтын түвшний нийт зардал 140,000.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 2,100.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,575.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор хэмнэгдсэн 3,902.9 мянган төгрөгийн зардлыг татан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12, зарлагын 2

мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 16 шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна. Байршуулбал зохих 159 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаандаа мэдээлсэн 156 мэдээлэл, хугацаа хоцорсон 1 мэдээлэл байна. Хуулийн хэрэгжилт 99.7 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 албан шаардлага, 4 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 1/14 тоотойр Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0.0	0	0.0	0
Албан шаардлага	5	436,317.2	5	436,317.2	100%
Зөвлөмж	4	46,828.7	4	46,828.7	100%
Нийт дүн	9	483,145.9	9	483,145.9	100%

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын зорилтот түвшинг үндэслэл сайтай тооцоолж төлөвлөн, хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан эсэх асуудлыг дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 23,143.8 мянган төгрөгийн 2 алдаа¹-г аудитын явцад залруулж, 7,300.0 мянган төгрөгийн 2 зөрчил²-ийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл 1.011.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу биелэлтийг тооцож тайлагнаагүй, тайлангийн тодруулга бэлтгэж хавсарган тайлангийн иж бүрдлийг хангаагүй алдаа байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, 8 дугаар зүйлийн 8.1.5-д “санхүүгийн тайлангийн тодруулга” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

2. Удирдлагын цалин, шимтгэлийн 22.132,3 мянган төгрөгийн зардлыг борлуулалтын өртгөөр тайлагнасан алдаа байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д “орлогын дэлгэрэнгүй тайлан”, 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “толилуулга”, “ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд, Заамар сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн тайланд өглөгөөр тусгагдаагүй, тооцоо нийлсэн баримтгүй, 7.300.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн, мөн өмнөх оны өглөгийн үлдэгдлээс 97,967.2 мянган төгрөгөөр өсөж, өглөгийн эцсийн үлдэгдэл 110,516.5 мянган төгрөг болж, нийт өмчийн 26,3 хувийг эзэлж байгаа, нийт хоорондын тооцооны 117,816.5 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө" заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.7-д "авлага өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй " бол албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудалд зөвлөмж өгч байна. Үүнд:

1. Төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, ДҮРЭМ-ийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д " Сумын ЗДТГ-тай байгуулсан Контрактын хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэнэ" заалтыг хэрэгжүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5.-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх зарчим" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл 1.011.5 мянган төгрөгөөр зөрүүтэй, зорилтот түвшний тайлангүй, тодруулга бичээгүй иж бүрдлийг хангаагүй алдаа байна.	1	1,011.5	1	1,011.5			1	1,011.5				
Удирдлагын цалин, шимтгэлийн 22.132.3 мянган төгрөгийн зардлыг борлуулалтын өртгөөр тайлагнасан алдаа байна.	1	22,132.3			1	22,132.3	1	22,132.3				
Дүн	2	23,143.8	1	1,011.5	1	22,132.3	2	23,143.8	0	0	0	0

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Харилцагч байгууллагын тайланд өглөгөөр тусгагдаагүй, тооцоо нийлсэн баримтгүй 7.300.0 мянган төгрөгийн авлага үүссэн, мөн өмнөх оны өглөгөөс 97,967.2 мянган төгрөгөөр өсөж, эцсийн үлдэгдэл 110,516.5 мянган төгрөг болж, нийт өмчийн 26,3 хувийг эзэлж байгаа нийт хоорондын тооцооны 117,816.5 мянган төгрөгийн зөрчил байна.	1	117,816.5			1	117,816.5						

